

XXI ЗУУНЫ МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО: СОРИЛТ БА ЗОРИЛТУУД

*Г.Төмөрчулуун**

Миний энд хэлэх зүйл бол судлаач хүний хувийн санал гэдгийг болгоон уу.

Гадаад бодлогод цаг хугацаа, орон зайны гурван хэмжүүр байдаг. Энэ нь гадаад бодлогын өнгөрсөн, өнөө, ирээдүй юм. Нөгөө талаасаа алив улсын гадаад бодлого гурван баганад тулгуурладаг. Эхний багана нь мэдээлэл, хоёр дахь багана нь дүн шинжилгээ, гурав дахь багана нь шийдвэр байдаг. Эдгээрийн аль нэггүйгээр гадаад бодлогыг төсөөлөхийн аргагүй. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцааг сайн судлан, эрүүл зөв дүгнэлт хийж, түүндээ үндэслэн ухаалаг стратеги боловсруулж хэрэгжүүлэхийг хэлж байгаа юм.

Өнөөдөр энэ гурван асуудалд та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна.

Мэдээлэл, дүн шинжилгээний хувьд өнөөгийн олон улсын харилцаа түргэн өөрчлөгдөн хөгжиж, даяаршил ид явагдаж байгаа нь хэн бүхэнд тодорхой асуудал.

Мэдээлэл, дүн шинжилгээ

Дэлхийн тавцан дээр БНХАУ, Энэтхэг, эдгээр улсыг дагасан Бразил, Индонези улс 2020 гэхэд дэлхийн бодлогод илүү чухал үүрэг гүйцэтгэнэ. АНУ хамгийн хүчирхэг, нөлөө бүхий гүрэн хэвээрээ байх боловч шинэ гүрнүүд, АНУ-ын хоорондын ялгаа улам багасна. Хүн амын ноцтой асуудалтай тулгараад байгаа Европын Холбоо, Япон хоёрыг БНХАУ, Энэтхэг хоёр ардаа орхино.

Шинэ нөхцөл байдалд Азийн үүрэг нөлөө эрс өсөж, Европын ач холбогдол буурна. XXI зуун Ази, Номхон далайн эрин зуун болж, энд даяаршил эрч хүчтэй өрнөж, дэлхийн эдийн засаг, улс төр, стратегийн бодлогыг бүхэлд нь хамрах төлөв төсөөлөл харагдаж байна. Чингэхдээ БНХАУ Зүүн Азийн эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр болох төдийгүй дэлхийн эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэхийг шинжилгээ судалгаа нотолж байна.

Зүүн Азид өрнөж буй интеграцчлалын гол онцлог бол бүс нутагт хоёр болон олон талт чөлөөт худалдааны бүс байгуулах үйл явц, ажиллагаа

*Г.Төмөрчулуун - доктор (Sc.D)

зонхилох хандлага болж байгаад оршино. Нийт Зүүн Азийн интеграцийн цөм бол АСЕАН-ны бүлэг улсууд, Япон, БНХАУ, Өмнөд Солонгос юм.

Өнөөгийн дэлхий ертөнцийн дүр зураг иймэрхүү байдлаар төсөөлөгдөж байна. Ийм нөхцөл байдалд далайд гарцгүй, жижиг эмзэг эдийн засагтай, хоёрхон улстай хиллэдэг, цөөн хүн амтай, бүс нутгийн улсуудтай газар нутаг, хил хязгаарын маргаангүй ийм онцлогтой Монгол Улс бүс нутгийн интеграцчлалд хамрагдах, дэлхийн мэдээлэл, технологи, худалдааны зах зээлд холбогдох, олон улсын хөгжлийн түншлэлийг хөгжүүлэх цэгцтэй цогц бодлого боловсруулан шат дараалсан арга хэмжээ хэрэгжүүлэх стратегийн зорилт зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улс ДХБ-ын гишүүн мөртлөө чөлөөт худалдааны хэлэлцээр өнөөг хүртэл нэг ч улстай байгуулаагүй цорын ганц улс юм. Иймд Монгол Улсын гадаад бодлогын нэг том зорилт бол зах зээл өндөр хөгжсөн орнуудтай түүний дотор, Зүүн Азийн орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах явдал мөн.

Энд би Монгол гэгч айлын гадаад бодлогын зөвхөн нэг чиглэлийг авч үзэхийг хүссэн юм. Тэр бол Азийн чиглэл. Ерөөс 2007-2012 оныг Монголын гадаад бодлогын Азийн таван жил гэж тодорхойлох саналыг дэвшүүлж байна. Тухайлахад 2006 он Их Монгол Улс байгуулагдсаны 800 ойн жил байлаа. Өнгөрсөн 95 жилд Монголын гадаад бодлогод болж байгаагүй үйл явдлууд ганцхан жилийн дотор болж өнгөрөв гэсэн хувийн дүгнэлтээ хэлье.

Тэгвэл Азийн таван жилийн хугацаанд Монгол Улс Зүүн Азийн хамтын нийгэмлэгийн нөлөө бүхий гүшүүн болсон байх учиртай. 5 жилийн хугацаанд Монгол нэгдүгээрт АПЕК-т элссэн байх ёстой. Хоёрдугаарт, Зүүн Азийн хамтын нийгэмлэг, ШХАБ-ын гишүүн болсон, АСЕАН болон түүний гишүүн орнуудтай түншлэлийн харилцаанд хүрсэн, бүс нутгийн хямралт асуудлуудыг шийдвэрлэхэд шударга брокер болох ёстой гэсэн зорилтыг өмнөө тавих нь зүйтэй.

Шийдвэр:

Эдгээр зорилтод хүрэхийн тулд дараах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Юуны өмнө гадаад харилцаа бие даасан төсөвтэй болох ёстой. Үүнд олон улсын байгууллагуудад төлдөг татварууд, ЗГХК-уудын төсөв, ДТГ-уудын төсөв, ГХЯ-ны төсөв зэргээс бүрдсэн гадаад харилцааны төсөв гэсэн нэгдсэн төсвийг УИХ-аар батлуулдаг журамтай болох нь зүйтэй байна.

Яагаад төсөв хөрөнгөний асуудал хурц байна гэхээр жишээ нь АСЕМ-ийн үйл ажиллагаанд хоёр жилд Монгол Улс 143 арга хэмжээнд оролцох ёстой болж байна. ШХАБ гэхэд жилд 50 арга хэмжээ, АПЕК-т элссэн нөхцөлд жилд 100 арга хэмжээнд оролцох болж байна. Эдгээр нь бүхэлдээ худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд юм. Гэтэл төсөв хаана байна?

Нэгэнт ийм зорилт дэвшүүлж байгаа учир ГХЯ-ны бүтцэд өөрчлөлт оруулах ёстой болно. Тухайлбал яамны бүтцэд олон талт интеграцийн нэгжийг байгуулах шаардлагатай. Энэ нэгжийг мэргэжлийн хүнээр бэхжүүлэх хэрэгтэй. Мөн яам хоорондын уялдаа холбоог энэхүү олон талт интеграци руу чиглүүлж өгөх хэрэгтэй.

Олон талт интеграцийн асуудал, түүнд Монгол Улсын оролцооны тухай ярихдаа мэргэжлийн боловсон хүчний асуудлыг хөндөлгүй орхиж болохгүй. Олон талт үйл ажиллагаа, эдийн засаг, бизнесийн удирдлага, интеграциар мэргэшсэн өндөр мэргэжилтэй, англи хэлний сайн мэдлэгтэй боловсон хүчнийг сургаж бэлтгэх том зорилт байна. Үүнтэй холбогдуулан ГХЯ-ны харъяанд сургалт, судалгааны төв байгуулах нь зүйтэй. Энэ төвийн нэг зорилго бол олон талт хамтын ажиллагаа, түншлэл, интеграцийн асуудлыг судалж, санал зөвлөлгөө өгөх явдал юм.

Эцэст нь нэг зүйлийг хэлэхийг хүсч байна. Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль Монгол Улсын гадаад бодлогыг үндсээр нь шинэчлэн өөрчилсөн баримт бичиг юм. Шинэ Үндсэн хуулийн заалтыг нарийвчлан томъёолсон 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлал Монголын гадаад бодлогод 4 томоохон өөрчлөлт оруулсан. Үүнд: гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэл, шийдвэр гаргах механизм.

Өнөөдөр түүнийг шинэчлэх тухай асуудал яригдаж байгаа. Энэ талаар саналаа хэлэхэд Гадаад бодлогын үзэл баримтлалын шинэ редакцийг УИХ-аар батлах шаардлагагүй гэж хувьдаа бодож байна. 1994 оны үзэл баримтлалд тусгагдсан Монгол Улсын гадаад бодлогын үндсэн зарчмууд, үзэл санаа хуучраагүй. Хөнгөн засварууд хийх шаардлага байгааг хүлээн зөвшөөрч байна.